



НИЙСЛЭЛИЙН ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

*Хараат бус судалгааны хүрээлэнгээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт
зориулан боловсрууллаа.*

2018 он



Нийслэлийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого

Нэг. Үндсэн асуудал

- 1.1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой бүтээн байгуулалт, үйлчилгээ, хөрөнгө оруулалтад хувийн хэвшлийн боломжит оролцоог хангах, боломж олгох, нийслэлийн хөгжлийн төлөө хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.
- 1.2. Нийслэлийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого нь энэ талаар төрөөс баримтлах бодлого, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, бусад хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан асуудлын бүрэлдэхүүн хэсэг байж уялдаатай хэрэгжинэ.
- 1.3. Энэхүү бодлогын баримт бичигт “**төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)**”-ийг “төрөөс иргэдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх аливаа төслийг төрийн ба хувийн хэвшлийн төлөөлөл хамтран хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа” гэж тодорхойлно.
- 1.4. Нийслэлд хэрэгжүүлэх ТХХТ-ийн төсөл, хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дараах нийтлэг шинжийг агуулсан байна.
 - ТХХТ-ийн төсөл, хөтөлбөр нь төр ба хувийн хэвшлийн субъект хооронд байгуулах урт болон дунд¹ хугацааны тогтвортой гэрээгээр хэрэгжинэ.
 - Хувийн хэвшил нь төрийн зарим чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах, төсөл хамтран хэрэгжүүлэх зэрэг үүрэг хүлээж түншлэлд оролцоно.
 - ТХХТ-ийн гэрээгээр түншлэлд оролцогч талууд хамтран ажиллаж эрсдэл болон үр ашгаа хуваах зарчим баримтална.
 - ТХХТ-ийг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч хувийн хэвшлийн субъект нь хөрөнгө оруулалтын өгөөжөө урт хугацаанд хүртэх боломжтой байна.

Хоёр. Бодлогын зорилго, зорилт, баримтлах зарчим

2.1. Бодлогын зорилго

Нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан ТХХТ-ийг дараах зорилгоор хэрэгжүүлнэ.

2.1.1. Нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулж дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах;

2.1.2 Хувийн хэвшлийн оролцоотойгоор нийслэлийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

2.1.3. Нийслэлийн эдийн засгийн харилцаан дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж төсвийн ачааллыг бууруулах, төрийн үйлчилгээний зардлыг бууруулж нийслэлийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх;

¹ Урт болон дунд хугацааг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд зааснаар ойлгоно.

2.1.4. Хувийн хэвшлийн оролцоотойгоор технологийн дэвшил, олон улсын туршлага, инновацийн ололт, менежментийн сайн арга барил, туршлагыг төрийн үйлчилгээний салбарт нэвтрүүлэх, энэ талын санал, санаачилгыг дэмжих.

2.2. Зорилт

Бодлогын зорилгуудын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

2.2.1. Нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулж дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах хүрээнд:

2.2.1.1 Нийслэлийн хөгжлийн бодлого дахь хувийн хэвшлийн оролцооны боломж, түвшинг тодорхойлох;

2.2.1.2. Хөрөнгө, санхүүгийн хомсдолоос шалтгаалан хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа төслүүдийг эрэмбэлж түншлэлээр хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлж байх;

2.2.1.3. Нийслэлийн хөгжлийн төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарах, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч байх.

2.2.2 Хувийн хэвшлийн оролцоотойгоор нийслэлийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд

2.2.2.1. Нийслэлийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.2.2.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаарх иргэд, ТББ, хувийн хэвшлийн санаачилгыг шийдвэр гаргах түвшинд нэн тэргүүнд анхаарах;

2.2.2.3. Төрийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог хангаж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлсэн олон улсын туршлага, кейсийг судалж турших, нэвтрүүлэх;

2.2.2.4. Түншлэлийн төслийн саналд төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаарх санаачилга, хувилбарыг тусгасан байдлыг чухалчилж үнэлэх.

2.2.3. Нийслэлийн эдийн засгийн харилцаан дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж төсвийн ачааллыг бууруулах, төрийн үйлчилгээний зардлыг бууруулж нийслэлийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх хүрээнд

2.2.3.1. Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх өртөг зардлын шинжилгээг хийж бусад хувилбартай ялангуяа хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхэд гарах зардалтай жишиж үр ашгийн тооцоог хийж байх;

2.2.3.2. Нийслэлийн хөгжлийн төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих, төсөл хэрэгжүүлэх төсвийн болон бусад санхүүжилтийн боломжит хувилбаруудыг тодорхойлох судалгааг хийж жилийн бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаж байх;

2.2.3.3. Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналд нийслэлийн төсвийн ачааллыг бууруулахад ямар дэмжлэг үзүүлэх талаар хувилбар, тооцооллыг чухалчилж үнэлэх.

2.2.4. Хувийн хэвшлийн оролцоотойгоор технологийн дэвшил, олон улсын туршлага, инновацийн ололт, менежментийн сайн арга барил, туршлагыг төрийн үйлчилгээний салбарт нэвтрүүлэх, энэ талын санал, санаачилгыг дэмжих хүрээнд

2.2.4.1. Төрийн үйлчилгээний салбарт түншлэлээр хэрэгжүүлэх төсөл нь байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлсэн, зардал бууруулсан төсөл байх шаардлагыг тавьж сонгон шалгаруулалт хийх;

2.2.4.2. Төрийн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлж байгаа олон улсын туршлагыг судалж нэвтрүүлэх;

2.2.4.3. Төрийн үйлчилгээний салбарт шинэ технологи, удирдлагын дэвшилтэт арга нэвтрүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг шийдвэр гаргах түвшинд нэн тэргүүнд анхаарч үзэх.

2.3. Бодлогын хэрэгжилтэд баримтлах зарчим

ТХХТ-ийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална.

2.3.1. Нийслэлийн ТХХТ-ийн бодлого нь Монгол улсын ТХХТ-ийн бодлоготой уялдсан, харилцан хамааралтай байх;

2.3.2. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх, нийслэлийн иргэдийн хувьд тэргүүлэх ач холбогдолтой байх;

2.3.3. Нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн бодлого, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байх;

2.3.4. Нийслэлийн төсвийн ачааллыг бууруулж эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

2.3.5. ТХХТ-ээр хэрэгжих төсөл хөтөлбөрийн сонголт нь ил тод, нээлттэй байх

2.3.6. ТХХТ-ийн оролцогч талууд харилцан үр ашигтай, эрсдэлээ хуваалцаж тэгш эрхтэйгээр хамтран ажиллах;

2.3.7. Нийслэлийн байгууллагууд ТХХТ-ийн нэгдсэн ойлголттой байж, нэг бодлогоор ТХХТ-ийг хэрэгжүүлэх;

2.3.8. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодоор хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангах, хэрэгжүүлэх;

2.3.9. Төрийн эрх мэдлийн төвлөрлийг бууруулах.

Гурав. ТХХТ-ийг хэрэгжүүлэх төрөл, хэлбэр

3.1. Нийслэлд хэрэгжих ТХХТ нь дараах төрөлтэй байна.

3.1.1. Дэд бүтцийн салбарын түншлэл: орон сууц, эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, тээвэр ложисток, мэдээлэл, харилцаа, холбоо, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, нийтийн зориулалттай барилга, байгууламж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр;

3.1.2. Нийгмийн салбарын түншлэл: боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, нийтийн биеийн тамир, спорт, аялал жуулчлалын салбарын төсөл хөтөлбөр;

3.1.3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх түншлэл: төрөөс олгодог зарим тусгай зөвшөөрөл, эрх, хяналтын үйл ажиллагааг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх, нийтийн аж ахуйн /нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, орчны тохижилт, цэцэрлэгжилтийн арчилгаа/ үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж төрийн албаны бүтэц, орон тоог оновчтой болгох, төсвийн ачааллыг бууруулах зорилготой төсөл, хөтөлбөр;

3.1.4. Байгаль орчны салбарын түншлэл: Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ус, бэлчээр, агаар, нээлттэй мэдээлэл зэрэг нийтийн нөөцийн удирдлагын төсөл хөтөлбөрийг түншлэлээр хэрэгжүүлэх.

3.2. ТХХТ-ийг салбарын онцлогтой уялдуулан дараах хэлбэрийг сонгож хэрэгжүүлнэ.

3.2.1. Дэд бүтцийн болон бусад салбарт хувийн хэвшлээс хөрөнгө оруулж урт болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх;

3.2.2. Ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр төсөл хэрэгжүүлэх;

3.2.3. Менежмент буюу удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх;

3.2.4. Түрээсийн гэрээ;

3.2.5. Түншлэгчдийн хувь нийлүүлсэн, нийслэлийн өмчит хуулийн этгээд байгуулж хөгжлийн төсөл хамтран хэрэгжүүлэх, эдийн засгийн үр ашиг хүртэхүйц үйл ажиллагаа эрхлэх;

3.2.6. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний онцлогоос хамаарсан бусад түншлэл.

Дөрөв. Түншлэлийн оролцогч талууд, эрх зүйн чадамж

4.1. Төрийг төлөөлөн дараах субъектүүд нийслэлийн хэмжээнд хэрэгжих ТХХТ-ийн төслийн оролцогч байна.

- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг;
- Нийслэлийн харьяа төрийн байгууллага;
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байна.

4.2. Түншлэлд оролцох хувийн хэвшлийн төлөөлөл дараах субъект байж болно.

- Компани: Монгол Улсад бүртгэлтэй, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай компани;
- Нөхөрлөл, хоршоо;
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод;
- Олон улсын мэргэжлийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий субъект;
- Хувь хүн.

4.3. Хувийн хэвшлийг төлөөлөн түншлэлд оролцогч талд тавих шаардлагыг түншлэлээр хэрэгжүүлэх төслийн тодорхойлолтод нарийвчлан заана.

4.4. Түншлэлд оролцох төрийн байгууллага, оролцоо: Түншлэлийн нэг оролцогч тал нь нийслэлийн эрх бүхий байгууллага байна. Түншлэлийг хэрэгжүүлэх эрхийг Нийслэлийн Засаг даргаас шилжүүлж өгөх ба дараах оролцоотой түншлэлийг хэрэгжүүлнэ.

4.4.1. Түншлэлийн оновчтой төрөл, хэлбэрийг сонгож хамтын ажиллагааны гэрээний нөхцлийг тохирч түншлэл амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх;

4.4.2. Орон нутгийн өмчийг түншлэлийн гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн талд эзэмшүүлж ашиглуулах тухай шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, ашигтай ажиллуулах;

4.4.3. Түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх үйлчилгээний үнэ тарифыг түншлэлд оролцогч талуудын эрх ашгийг харгалзан тогтоох;

4.4.4. Санхүүжилтийн баталгаа, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, татварын хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээний нийлүүлэлтийн давуу эрх олгох зэрэг түншлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх;

4.4.5. Түншлэлийн явцад үүссэн эрсдэл ба боломжийг харилцан хуваах шийдвэрийг түншлэлийн гэрээний болон үйлчлэх эрх зүйн орчинд тохируулан гаргах;

4.4.6. Хувийн хэвшилтэй бизнесийн зарчмаар харилцан ашигтай түншлэх.

4.5. Түншлэлийг хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн оролцоо: түншлэлийг үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж дараах үүргийг гүйцэтгэнэ.

4.5.1. Түншлэлийн оновчтой төрөл, хэлбэрийг сонгож түншлэл амжилттай хэрэгжихүйц гэрээний нөхцөлийг тохирч хэрэгжүүлэх;

4.5.2. Бизнесийн салбарт гарч байгаа техник, технологийн дэвшилтэт шийдэл, мэдлэгийг түншлэлийн талбарт нэвтрүүлэх;

4.5.3. Түншлэлд оролцогч төрийн байгууллага, албан хаагчдын чадавхийг бэхжүүлж туршлагаа хуваалцах;

4.5.4. Төсвийн ачааллыг бууруулж хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тохиромжтой хувилбарыг санал болгох;

4.5.5. Түншлэлийн хүрээнд үзүүлэх төрийн үйлчилгээний чиглэлийг өөрчлөхгүй үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

4.5.6. Нийслэлийн өмчийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлэх;

4.5.7. Нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн байгууллагатай түншлэх.

Тав. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг батлах, төсөлд тавигдах үндсэн шалгуур

5.1. Түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хүлээн авч эрэмбэлэн ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг бэлтгэх үүргийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг хүлээнэ.

5.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж жагсаалтыг хянан, дүн шинжилгээ хийж, эцэслэсний дараа төслийн саналын жагсаалтыг Нийслэлийн Засаг даргаар уламжлан НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд хүргүүлж батлуулна.

5.3. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт дараах ерөнхий шаардлага тавигдана.

5.3.1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилго болон бусад бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд чиглэх;

5.3.2. Нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байх;

5.3.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилтуудад тусгагдсан байх;

5.3.4. Нийслэлийн иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшлэх нь төсөл, хөтөлбөрийн урьдчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээр нотлогдсон байх;

5.3.5. Нийслэлийн төсвийн ачааллыг бууруулж түншлэл хэрэгжсэнээр орон нутгийн өмчийн үр ашиг дээшлэх үндэслэлтэй байх;

5.3.6. Тухайн үйл ажиллагааг төрөөс дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх нь ТЭЗҮ-ээр нотлогдсон байх;

5.3.7. Түншлэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь нийслэлийн иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн, байгаль орчинд ээлтэй технологитой, үндэсний аюулгүй байдлын баталгааг хангасан байх;

5.4. Нийслэлд ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг сонгох, хэрэгжүүлэх журмыг энэхүү бодлогод нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ.

Зургаа. ТХХТ-ээр хэрэгжих үйл ажиллагааны санхүүжилт

6.1. ТХХТ-ээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилтийн дараах хэлбэрүүдийг ашиглана.

6.1.1. Урт хугацааны гэрээг үндэслэн хувийн хэвшлээс хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэр;

6.1.2. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын зүйлд олгох улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;

6.1.3. ТХХТ-ээр хэрэгжих төслийн үйл ажиллагааны орлого, төлбөрт үйлчилгээний орлого;

6.1.4. Түншлэгч талууд хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргах замаар бүрдүүлсэн санхүүжилтийн эх үүсвэр;

6.1.5. Олон улсын байгууллага, төр, хувийн хэвшил, иргэдийн зүгээс ТХХТ-ийн төслийг дэмжиж өгсөн хандив, тусламж;

6.1.6. Эрх зүйн актуудад нийцүүлэн санхүүгийн зах зээлээс босгосон нэмэлт санхүүжилт;

6.1.7. Хөрөнгө оруулагч талуудад ногдох хувьцааны ногдол ашиг, ногдол ашгийн хуваарилалтаас орох санхүүжилт;

6.1.8. ТХХТ-ийн эрх зүйн орчинд зөвшөөрөгдсөн бусад санхүүжилтийн эх үүсвэр.

6.2. Түншлэлийн үйл ажиллагаанд тохиромжтой санхүүжилтийн оновчтой хувилбарыг сонгож хэрэгжүүлэх үүргийг түншлэлд оролцогч талууд хүлээж түншлэлийн гэрээнд тодорхой тусгана.

Долоо. Нийслэлийн ТХХТ-ийн эрх зүйн орчныг бүрдүүлэх

7.1. Нийслэлийн ТХХТ-ийн бодлого нь Монгол улсын төрөөс энэ талаар баримтлах бодлого, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль болон бусад хуульд нийцсэн байна.

7.2. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх журмыг Нийслэлийн НИТХ-аас баталж мөрдүүлнэ.

7.3. Нийслэлийн ТХХТ-ийн бодлогыг хэрэгжүүлэх журамд бодлогын хэрэгжилтийг хангахад оролцогч талууд, тэдгээрийн чиг үүргийн хуваарилалт, ТХХТ-ийн төслийг сонгох үе шат, төслийн шалгуур, төслийг сонгох аргачлалыг тусгана.

Найм. ТХХТ-ийг хэрэгжүүлэх хугацаа, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах зарчим

8.1. ТХХТ-ийн энэхүү бодлогын баримт бичгийг дараах үе шатаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат: (2018-2021) Нийслэлд ТХХТ-ийг амжилттай хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, ТХХТ-ийг хөгжүүлж дэд бүтэц, нийгмийн салбарт шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;

Хоёрдугаар үе шат: (2021-2025) Нийслэлийн эдийн засаг, төрийн үйлчилгээний хүрээнд хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг эрчимтэй нэмэгдүүлэх үе.

8.2. Дараах тохиолдолд энэхүү бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулна. Бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах үндэслэлийг Нийслэлийн Засаг даргын удирдлага дор Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж боловсруулж өөрчлөлтийг НИТХ-аар батална.

- Төрөөс ТХХТ-ийн талаар баримтлах бодлого, түүнийг дагаж гарсан журам, эрхзүйн актуудад өөрчлөлт орсон;
- Нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг, эрх зүйн актуудад өөрчлөлт орсон;

- ТХХТ-ийг хэрэгжүүлсэн практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зохистой хувилбарыг түншлэлд оролцогч талуудаас тодорхойлсон;
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг түншлэлд оролцогч талуудын эрх зүйн чадамжийг тодорхойлох гол хуулиудад өөрчлөлт орсон;
- Улс орны болон Нийслэлийн нийгэм, эдийн засагт гарсан томоохон өөрчлөлт, түүнийг дагаж бодлогыг өөрчлөх үндэслэл бүхий нөхцөл үүссэн;
- Бодлогод тодорхойлсон харилцааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн болон тухайн асуудал байхгүй болсон тохиолдолд.

Ес. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ

9.1. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж НИТХ-д тайлагнах үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч хүлээнэ.

9.2. ТХХТ-ийн төсөл тус бүрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг түншлэлийн гэрээнд тусгаж талууд шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг үнэлэх үүргийг түншлэлийн талууд хүлээнэ.

9.3. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээг хийх чиг үүргийн хуваарилалтыг энэхүү бодлогыг дагаж гарах журамд тодорхой тусгана.

9.4. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, бодлогын хэрэгжилт, оролцогч талуудын оролцоог үнэлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох шийдвэрийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, НИТХ гаргана.